



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 23 № 64

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайланд онд төсвийн хөрөнгөөр 63,622.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 657,743.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Авлага дансны үлдэгдэл 1,714,561.2 мянган төгрөг болж, 1,689,413.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 791,206.5 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй, холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2023 оны 01 сарын 09-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 чиг үүрэг, 6 зорилгын хүрээнд 106 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд 66 арга хэмжээг үр дүнтэй буюу 100.0 хувь, 35 арга хэмжээг тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0-99.0 хувь, 2 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай буюу 31.0-69.0 хувь, 3 арга хэмжээг үр дүнгүй буюу 0-

0702900226

30.0 хувиар дүгнэж биелэлтийг 88.0 хувьтай хүргүүлсэн боловч ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,692,616.7	3,808,788.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,583,656.5	19,258,691.3
Нийт хөрөнгийн дүн	22,276,273.2	23,067,479.7
Нийт өр төлбөрийн дүн	812,885.8	1,429,230.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	21,463,387.5	21,638,249.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	22,276,273.2	23,067,479.7
Үйл ажиллагааны орлогын дүн	15,295,847.1	14,300,811.2
Үйл ажиллагааны зардлын дүн	13,500,609.4	14,124,321.4
Үйл ажиллагааны үр дүн	1,795,237.7	176,489.8
Үйл ажиллагааны бус үр дүн	1,687,458.6	176,489.8
Үйл ажиллагааны нийт үр дүн	15,295,847.1	14,300,811.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,066,952.4	21,463,387.5
Тайлант оны үр дүн	1,687,458.6	174,862.0
Эцсийн үлдэгдэл	21,463,387.5	21,638,249.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	11,200,270.9	11,326,926.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	11,186,107.6	10,790,819.3
Үйл ажиллагааны ЦМГ	14,163.3	536,107.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(18,127.9)	(63,622.3)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(3,964.6)	472,485.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,039.1	6,074.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,074.5	478,559.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	12,891,301.4	10,854,441.6
Урсгал зардал	12,891,301.4	10,854,441.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	12,891,301.4	11,326,926.8
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,268,492.3	2,265,323.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,815,291.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Байгууллагын 3 нэгж талбарын газрын бүртгэлийг 1,617.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Авлагын дэлгэрэнгүй тайланд Сүвэн-Уул ХХК-иас 3,980.0 мянган төгрөгийн эмийн авлагыг тусгаагүй. Өглөгийн тайланд 3,980.0 мянган төгрөгийн авлагыг хасах дүнтэйгээр тусгасан,
- Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 2,610.0 мянган төгрөгийн эм боох материалыг зөрүүтэй, тайлагнасан,
- Өмчийн өөрчлөлтийн тайланд 291,023.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн есөлт бууралтыг бүртгээгүй,
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 1,190,132.1 мянган төгрөгийн дахин үнэлгээний хорогдлыг акталсан дансанд тусгаж зөрүүтэй тайлагнасан,
- Бодитоор ирээгүй 324,727.7 мянган төгрөгийн хог хаягдлыг устгах автоклавыг эд хөрөнгийн тооллогоор тоолсон, хөрөнгөд бүртгэснийг залруулсан.
- Барилгын засварын зардлаас 1,200.0 мянган төгрөгийн 16 ширхэг хөрөнгийг зарлагадсан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заалтыг зөрчсөн байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой: Шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 660,673.1 мянган төгрөгийн 51 гүйлгээ мэдээлээгүй, 10,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг хоцроосон, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 406,764.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, төсөв өмч хөрөнгө зарцуулсан 3,512.9 мянган төгрөгийн 1 тушаалыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 27,064.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 27,064.4 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 25,055.9 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 2,008.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

3.1 Төлбөрийн акт

1. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй 2 албан хаагчид нууц хамгаалах ажилтны нэмэгдэл 2,008.5 мянган төгрөгийн үндэслэлгүйгээр олгосон нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно.", 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон нууцын нэмэгдлийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Захирлын тушаалаас үр дүнгийн урамшууллыг 13,106.4 мянган төгрөгөөр дутуу, 1,046.5 мянган төгрөгийн илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан 3 дугаар зүйлд 3.6-т "Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг "бүрэн хангалттай", "хангалттай" гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ", 3.10-т "Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана", Аймгийн нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны 04 сарын 24-ны өдрийн Б/29 дугаар тушаал, 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/65 дугаар тушаал, 2023 оны 10 дугаар сарын 25-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ны өдрийн Б/93 дугаар тушаал, 2023 оны 12 сарын 22-ны өдрийн Б/111 дугаар тушаалтай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Улирлын ажлын урамшууллыг байгууллагын даргын шийдвэрт заасны дагуу олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Аж ахуйн тасгийн дарга, аж ахуйн тасгийн ахлах инженер, нягтлан бодогч нарт 4,870.1 мянган төгрөгийн хариуцлагын нэмэгдлийг олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ", Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/69 дугаар тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.9-т "Эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох"; Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/09 дугаар 01 дүгээр хавсралт "Нэгдсэн эмнэлгийн дүрэм"-ийн 6.5 Эд хөрөнгийн хариуцлага 6.5.2-т Хангамж, аж ахуй, инженер техникийн албаны дарга, үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга нь нягтлан бодогч, нярав, ахлах сувилагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг хөдөлмөрийн гэрээндээ нэг бүрчлэн тусгаж гэрээг бичгээр байгуулна." гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдэл олгож буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Ажлын байрны үндсэн чиг үүрэгт хамаарах 6 албан хаагчид 2023 онд 6,032.9 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах"; 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдэл олгож буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд 136 нэр төрлийн 205,776.8 мянган төгрөгийн тавилга, эд хогшлын шинж агуулсан хөрөнгийг бүртгэсэн нь Бараа материалын дансанд 270,341.6 мянган төгрөгийн 173 ширхэг үндсэн хөрөнгийн шинж агуулсан хөрөнгийг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэх албан шаардлага хүргүүлсэн.

5. Эм боох материалын үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийхэд ковидын үед хандив, тусламжаар ирсэн 2 нэр төрлийн 130,847.7 мянган төгрөгийн эмийн хугацаа дууссан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэгдсэн эмнэлэг	8	1,815.3	-	-	8	1,815.3	8	1,815.3	-	-	-	-
Дүн	8	1,815.3	-	-	8	1,815.3	8	1,815.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэгдсэн эмнэлэг	6	27.1	1	2.0	5	25.0	-	-	-	-	-	-
Дүн	6	27.1	1	2.0	5	25.0	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ		1			1				
	НИЙТ		1			1				